



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ

Үндэсний аудитын газрын 2018 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

АУДИТЫН НЭР: “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”

АУДИТЫН КОД: ГАГ/БНАТАГ-/2018/01-ГА



Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг батлахдаа үр ашгийн тооцоо, судалгаа, зайлшгүй хэрэгцээ шаардлага зэргийг үндэслээгүй байна. .

**Баянхонгор хот
2018.05.22**

АГУУЛГА

	Товчилсон Үгийн тайлбар.....	1
	ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН.....	2
	“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2017 ОНД САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ”-Т ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН.....	4
	Ерөнхий мэдээлэл	4
	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөөгүй байна.....	4
	1.1. Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг батлахдаа үр ашгийн тооцоо, судалгаа, зайлшгүй хэрэгцээ шаардлага зэргийг үндэслээгүй байна.	4
	1.2. Техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гараагүй төсөл, арга хэмжээг баталж Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна.	6
	1.3. Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй төсөл, арга хэмжээг баталсан байна.	7
	Хөрөнгө худалдан авсаны дараа худалдан авах ажиллагааг зохион байгуулж хууль зөрчсөн байна.	7
	2.1. Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хөрөнгө худалдан авсаны дараа зохион байгуулжээ.	7
	2.2. Үнэлгээний хорооноос хүргүүлсэн шууд гэрээ байгуулах зөвлөмжийн дагуу гэрээ байгуулахдаа техникийн тодорхойлолтод заасан нөхцлийг харгалзаж үзээгүй байна.	9
	2.3. Зарим гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ зөрчиж, ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй байхад хариуцлага тооцож ажиллаагүй байна.	9
	2.4. Гэрээнд заасан санхүүжилтийг бүрэн олгосон байна.	10
	2.5. Гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байгаагаас хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгө ашиглагч байгууллагын өмчлөх эрхэд шилжээгүй байна.	11
	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн зарим хөрөнгө оруулалтын үр нөлөө гараагүй байна.	11
	3.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.	11
	3.2 Тендерийн хэмнэлтийг бусад зардалд зарцуулаагүй байна.	15
	3.3. Зарим хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.	15
	АУДИТЫН ДҮГНЭЛТ	16
	АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	17
Тайланг бэлтгэсэн:		
Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар		
<i>Уг тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын</i>		
<i>Цахим хуудаснаас үзнэ үү:</i>		
<u>www.audit.bayankhongor.mn</u>		
<i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442584, 70442424 дугаарын утсаар харилцана уу.</i>		
Хаяг: Баянхонгор сум, Номгон 1- р баг, Төр захиргааны ордон 3-р давхар		

Товчилсон Үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
БСУГ	Боловсрол, соёл, урлагийн газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Хавсралт маягтын жагсаалт

Судалгаа № 1	Аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан төсөл арга хэмжээний судалгаа
Судалгаа № 2	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний 2017 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны судалгаа
Судалгаа № 3	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилт, санхүүжилтийн судалгаа
Судалгаа № 4	“Баянхонгор хөгжлийн корпораци” ХХК-аас олгосон хөнгөлөлттэй зээлийн судалгаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 тоот тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ:

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх.

Аудитад улс, орон нутгийн төсвөөс 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг аймгийн ЗДТГ, ХОХБТХ, ОНӨГ-ын хүрээнд аудитыг гүйцэтгэв.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүй болон гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/-ийг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, мэдээ судалгааг ажлын баримтад хавсаргав.

Ингэхдээ холбогдох хууль, эрхийн актыг судлах, татварыг хөнгөлж, чөлөөлсөн мэдээ, судалгаанд дүн шинжилгээ хийх, холбогдох байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага, асуулга, лавлагаа авах зэрэг аргуудыг ашиглав.

Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа:

Дараахь хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын төсвийн тухай хууль;
 - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
 - Барилгын тухай хууль;
 - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
 - Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
 - Сангийн сайдын 2012 оны 264-р тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
 - Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”;
 - 2017 оны төсвийн тухай хууль, аймгийн ИТХ-ын тогтоолоор Баянхонгор аймагт хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээ
 - Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан дүрэм, журам, бусад эрх зүйн актууд
- Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдан, аудитын менежер Д.Цэцэгмаа аудитын үе шат бүрт хяналт тавьж, ахлах аудитор Б.Должмаа, аудитор Б.Азбаяр нар 2018 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 05 дугаар сарын 03-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитыг ҮАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу хийж, аудитын танилцуулга, хавсралт судалгаануудыг ҮАГ-т хүргүүлж ажиллав.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний хувьд дарга, тэргүүлэх аудиторовын баталсан дэд хөтөлбөрийн дагуу хийж, аудитын тайлан бэлтгэж, улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын танилцуулгын хамт орон нутгийн удирдлагуудад хүргүүллээ.

**“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2017 ОНД
САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ”-Т ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

Ерөнхий мэдээлэл

Аймгийн Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/623 тоот захирамжийн дагуу аймгийн Төрийн сан дахь ангилагдаагүй зардлын дансны нэгдүгээр гарын үсгийг СТСХ-ийн дарга, хоёрдугаар гарын үсгийг төсвийн ерөнхий нягтлан бодогч нар зурж, хөрөнгийг аймгийн Засаг даргын захирамжаар захиран зарцуулжээ.

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл арга хэмжээг аймгийн ИТХ-аар батлахдаа ангилагдаагүй зардалд оруулан баталж, санхүүжилтийг аймгийн Төрийн сан дахь “Орон нутаг” гэсэн 100030051000 тоот дансаар дамжуулсан байна. 2018 оноос орон нутгийн хөрөнгө оруулалтад батлагдсан 910,0 сая төгрөгийн санхүүжилтийг ангилагдаагүй зардлын дансаар дамжуулаагүй, “Орон нутгийн хөрөнгө оруулалт” дансаар дамжуулж байгаа гэсэн тайлбарыг төсвийн ерөнхий нягтлан бодогч хийсэн болно.

Аймгийн ИТХ-аас Орон нутгийн хөрөнгө оруулалтыг ангилагдаагүй зардалд оруулан баталж байгаа бөгөөд аудитад хөрөнгө оруулалтын шинж чанартай зардлыг хамруулан шалгасан ба урсгал зардлыг аудитад хамруулаагүй.

**БҮЛЭГ
1**

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх?

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөөгүй байна.

1.1. Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг батлахдаа үр ашгийн тооцоо, судалгаа, зайлшгүй хэрэгцээ шаардлага зэргийг үндэслээгүй байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2016 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн 4/2 тоот тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар ангилагдаагүй зардалд 13 хөтөлбөр /тус арга хэмжээнд үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал багтсан/ арга хэмжээнд 472,7 сая төгрөг баталж 2017 оны 1,6,11 дүгээр саруудад

3 удаа тодотгол хийж, 12 дугаар сард аймгийн Засаг даргын захирамжаар төсөвт зохицуулалт хийж, 2017 онд нийт 2311,6 сая төгрөгийн 42 төсөл, арга хэмжээг

санхүүжүүлэхээр баталсан байна.

/Хавсралт судалгаа №1/

Дээрх арга хэмжээнээс Төсвийн тухай хуулийн 4.1.24¹-т заасан хөрөнгө оруулалтын шинж чанартай 1377,0 сая төгрөгийн 25 төсөл арга хэмжээг аудитад хамруулсан ба төсөл арга хэмжээний 42,8 хувь буюу 589,7 сая

төгрөгийг хөрөнгө худалдан авахад, 3,8 хувь буюу 52.3 сая төгрөгийг барилга засварын ажилд, 53,4 хувь буюу 735.0 сая төгрөгийг төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд баталжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн төсөл арга хэмжээнээс 8 төсөл арга хэмжээ байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй байгаа талаар холбогдох байгууллагуудаас албан бичгээр аймгийн ЗДТГ-т хүсэлт ирүүлсэн, харин бусад төсөл, арга хэмжээний хувьд батлагдсан маягтын дагуу хийсэн тооцоолол, судалгаа байхгүй байгаа нь Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 3.10 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна. Мөн төлөвлөлтийн шатны ажлыг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтсийн оролцоогүйгээр СТСХ-ийн мэргэжилтэн хариуцаж гүйцэтгэж ажлын уялдаа холбоогүй ажилласан байна.

Иймд орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд ХОХБХ, СТСХ-ийг ажлын уялдааг сайжруулах, ХОХБХ-ийг оролцоог нэмэгдүүлж, 2018 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээнд дотоод хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгах холбогдох арга хэмжээг авч, цаашид энэ зөрчлийг давтан гаргахгүй, Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ыг

¹ "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ"

мөрдөж, журмын нэгдүгээр хавсралтаар батлагдсан маягыг бэлтгэж, аймгийн ИТХ-аар батлуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Хөрөнгө оруулалтын төсвийн төлөвлөлтийг журмын дагуу хийгээгүй, хэдэн төсөвт байгууллагаас ямар саналууд ирсэн, түүнийг хэрхэн шийдвэрлэснийг гаргасан судалгаа байхгүй, улсын төсвөөс санхүүждэг аймгийн Шүүх, Прокурор, Цагдаа, Татвар, ШШГГ зэрэг байгууллагуудад орон нутгийн төсвөөр хөрөнгө бэлтгэж өгсөн нь Төсвийн тухай хуулийн 6.6.6² дахь заалтыг зөрчиж байна.

1.2. Техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гараагүй төсөл, арга хэмжээг баталж Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна.

Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнээс ТЭЗҮ, зураг төсөв шаардагдах 2 ажил батлагдсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг техникийн тодорхойлолт гаргаагүй, ТЭЗҮ хийгдээгүй байхад төсөвт тусгаж баталсан нь Төсвийн тухай хуулийн 29.4³-т заасныг зөрчсөн байна. Тухайлбал:

2017 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар зураг, төсөв шаардах их засварын 2 ажилд 49.5 сая төгрөг баталснаас аймгийн Татварын хэлтсийн халаалтын засварын ажил нь зураг хийгдээгүй, төсвийг тэргүүлэх төсөвчин Б.Алтанцэцэг хийж гүйцэтгэсэн, аймгийн Прокурорын газрын дээврийн засварын ажилд зураг хийгдээгүй, төсвийг 2016 онд “Баянговгор” хоршооны инженер С.Амарзаяагаар хийлгэсэн боловч албан ёсоор гарын үсгээр баталгаажуулаагүй, зураг төсвийг мэргэжлийн төсөвчин хийсэн эсэх нь тодорхойгүй байна.

Дээрх 2 засварын ажлаас бусад төсөл, арга хэмжээг урьдчилан төлөвлөөгүй, зах зээлийн үнийн судалгаанд үндэслэн техникийн тодорхойлолтыг гаргаагүй байхад баталжээ.

Иймд цаашид хөрөнгө оруулалтын жагсаалтыг батлахдаа Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 415 тоот тушаалаар тодорхойлсон техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, барилга

² " тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх"

³ "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана"

байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдэл, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, хууль, журамд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын ач холбогдолтой нь уялдуулан тусгаж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

1.3. Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй төсөл, арга хэмжээг баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 81, 104, 107, 147, Баянхонгор аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 97, 143, 147, дахь заалтуудад тусгагдсан зорилт, салбарын бодлого чиглэлтэй уялдсан гэсэн судалгааг ирүүлсэн байгаа боловч доорх арга хэмжээг ямар заалтай уялдаж байгааг нотлох баримт бичиг ирүүлээгүй болно. Тухайлбал:

Аймгийн МХГ-т тоног төхөөрөмж худалдан авах, Татварын хэлтсийн халаалтын засвар, аймгийн Прокурорын газрын дээврийн засвар, Зооноз өвчин судлалын төвийн лабораторийн урсгал засвар зэрэг ажлууд нь хөгжлийн бодлогын ямар баримт бичгүүдэд тусгагдаагүй байна.

БҮЛЭГ 2

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх?

Хөрөнгө худалдан авсаны дараа худалдан авах ажиллагааг зохион байгуулж хууль зөрчсөн байна.

2.1. Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хөрөнгө худалдан авсаны дараа зохион байгуулжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр батлагдсан 641,2 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг аймгийн ОНӨГазар зохион байгуулснаас 11 нь харьцуулалт, 5 нь нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар зохион байгуулж, үүнээс аймгийн Прокурорын дээврийн засварын ажлын тендерийг цахимаар, бусад тендерийг цаасаар зарласан байна. /Хавсралт судалгаа №2/

Батлагдсан төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг баримттай нь тулган шалгахад дараах зөрчилүүд илэрлээ. Тухайлбал:

- *Засаг даргын хэрэгцээнд суудлын автомашины авах урьдчилгаанд төсвөөс 2017 оны 07 дугаар сарын 26-ны өдөр 54,0 сая төгрөгийг шилжүүлсэн байхад үнэлгээний хороог 2017 оны 08 дугаар сарын 02-ны өдөр байгуулж, нээлттэй тендер сонгон шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулсан боловч нэг ч аж ахуйн нэгж материал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдөр хүргүүлсэн зөрчил илэрлээ. Тус автомашиныг хууль зөрчин худалдан авсан асуудлыг Авлигатай тэмцэх газар шалгасан ба шалгалтын дүнгийн талаар ямар нэгэн мэдээлэл байхгүй байна.*
- *Аймгийн Татварын хэлтсийн халаалтын засварын тендерт 3 компани оролцсноос “Эх бүрдэн” ХХК тус ажлыг 17018,1 мянган төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарсан байхад аймгийн Засаг даргад хүргүүлсэн зөвлөмжийн мөнгөн дүнг засварласан, он, сар, өдрийг бичээгүй зөрчилтэй байна.*
- *2017 онд Эрдэнэцогт сумын ЗДТГ-т суудлын автомашин нийлүүлэх тендерийн урилгын техникийн тодорхойлолтод 2014 оноос хойш үйлдвэрлээдсэн 4000-4500см3 хөдөлгүүрийн багтаамжтой Toyota Land cruiser 76,77-той дүйцэхүйц суудлын автомашин, Шинэжинст сумын ЗДТГ-т 2011 оноос хойш үйлдвэрлэсэн, 2013 оноос хойш Монголд орж ирсэн, 4000-4500 см3 хөдөлгүүрийн багтаамжтай Toyota Land cruiser 200 маркын суудлын автомашин авахаар заасан боловч нэг ч тендерийн материал ирээгүй нь техникийн тодорхойлолтыг өндөр тавьж өрсөлдөх боломжийг хязгаарласаны улмаас нэг ч тендерийн материал ирээгүй байна.*

Дээрх зөрчлөөс үзэхэд тендер зарлахдаа үнийн судалгаа хийдэггүй, тендерийн үнэнд мэргэжлийн байгууллага болох аймгийн ОНӨГ хяналт тавиагүй, суудлын автомашин урьдчилан бэлдээд, тендерийг амжилтгүй болсоны дараа техникийн тодорхойлолтод нийцэхгүй хөрөнгө бэлтгэж байгаагаас харахад ашиг сонирхлын зөрчилтэй байж болзошгүй байна. Аймгийн ИТХ-аас ирүүлсэн захиалгын дагуу дараагийн аудитаар худалдан авах ажиллагааны талаар нийцлийн аудит хийгдэх тул уг асуудлыг тодруулан шалгахаар болов.

Иймд цаашид ТБОНӨХБАҮХАТ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1⁴ дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв.

⁴ “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.”

2.2. Үнэлгээний хорооноос хүргүүлсэн шууд гэрээ байгуулах зөвлөмжийн дагуу гэрээ байгуулахдаа техникийн тодорхойлолтод заасан нөхцлийг харгалзаж үзээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд суудлын автомашин худалдан авах тендерийг харьцуулалтын аргаар зарласан боловч нэг ч аж ахуйн нэгж материал ирүүлээгүй тул үнэлгээний хороо 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдөр аймгийн Засаг даргад шууд гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсний дагуу “Балчаа” ХХК-тай 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр шууд гэрээг байгуулж, 04 дүгээр сарын 06-ны өдөр “Alphard” маркын суудлын автомашиныг хүлээн авсан байна. Үнэлгээний хорооноос гэрээг аймгийн ОНӨГ-аар хянуулахыг зөвлөсөн, техникийн тодорхойлолтод “үйлдвэрлэсэн он 2010 оноос хойш” гэж заасан байхад гэрээг хянуулаагүйгээс 2003 онд үйлдвэрлэсэн суудлын автомашиныг худалдан авсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2⁵-т заасныг хангахгүй байна. Иймд үнэлгээний хорооноос шууд гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн ажилд шууд гэрээ байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34 дүгээр зүйлийг мөрдөж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2.3. Зарим гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ зөрчиж, ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй байхад хариуцлага тооцож ажиллаагүй байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газарт 14,1 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн “Грийн номгон” ХХК гэрээний хугацаанаас 3 хоног, аймгийн Прокурорын газрын дээврийн засварын ажлыг гүйцэтгэсэн Зэвсэгт хүчний 339-р анги 29 хоног, аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газарт тоног төхөөрөмжийг нийлүүлсэн “Цэлмэг өглөө” ХХК 10 хоног тус тус хэтрүүлж хүлээлгэн өгсөн байна.

Аймгийн Прокурорын газартай байгуулсан гэрээнд хариуцлага тооцох заалт байхгүй, МХГ-тай байгуулсан гэрээнд хугацаа хожимдуулсан тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5%-ийн алданги тооцох, аймгийн ШШГГ-тай байгуулсан гэрээнд хуулийн дагуу хариуцлага тооцохоор заасан байхад хариуцлага тооцож ажиллаагүй байна.

⁵ “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.”

Иймд гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулахдаа гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд тооцох хариуцлагыг тодорхой зааж, үүргээ биелүүлээгүй нөхцөлд хариуцлага тооцож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2.4. Гэрээнд заасан санхүүжилтийг бүрэн олгосон байна.

2017 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан 25 төсөл арга хэмжээнд 1373,7 сая төгрөгийн гэрээ байгуулж, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

№	Төсөл, арга, хэмжээний нэр	Батлагдсан дүн	Гүйцэтгэлээр олгосон	Зөрүү
1	АЗДТГ орон сууц авах зардал	52,000,000	52,000,000	-
2	Цагдаагийн газрын орон сууц худ авах	52,000,000	51,975,000	25,000
3	Шүүхийн Ерөнхий шүүгчийн орон сууц авах	52,000,000	52,000,000	-
4	ЗДТГ-ын автомашины үнэ	17,000,000	17,000,000	
5	ЗДТГ автомашины үнэ	180,000,000	180,000,000	
6	Богд сум автомашин	15,000,000	15,000,000	
7	Эрдэнэцогт сум автомашин	15,000,000	15,000,000	
8	Шинэжинст сум автомашин	15,000,000	15,000,000	
9	МХГ-ын тоног төхөөрөмж худалдан авах	15,000,000	14,100,000	900,000
10	Татварын хэлтсийн халаалтын засвар	18,000,000	17,018,110	981,890
11	Татварын хэлтсийн авто машин худалдан авах	70,000,000	69,500,000	500,000
12	Аймгийн прокурорын газрын дээврийн засвар	31,500,000	31,021,200	478,800
13	Цагдаагийн газрын POLICE READER төхөөрөмж	9,790,000	9,790,000	-
14	Газар тариаланг дэмжих	35,000,000	35,000,000	-
15	Зээлийн батлан даалтын сан	50,000,000	50,000,000	-
16	ЖДҮ дэмжих зээл	560,000,000	560,000,000	-
17	Мотоцикл /Багийн эмч, сумын хэсгийн байцаагч/	34,000,000	33,800,000	200,000
18	Зөөврийн компьютер Багийн ЗД	29,116,000	28,996,000	120,000
19	Олон нийтийн цагдаагийн хэрэгсэл	8,114,400	8,114,400	-
20	ШШГГ тоног төхөөрөмж	7,730,400	7,703,000	27,400
21	Захи№634 УБХ Архивын шүүгээ	7,000,000	7,000,000	-
22	Захирамж№371 Баян-Овоо сумын 3 багийн мотоциклын үнэ	5,400,000	5,400,000	-
23	Захирамж№527 Явуулын мал эмнэлэг 2 гэр	5,600,000	5,600,000	-
24	Малжуулах хөтөлбөр	90,000,000	90,000,000	-
25	Зооноз өвчин судлалын төвийн лабораторийн урсгал засвар /вакум хаалт/	2,760,000	2,760,000	-
	ДҮН	1,377,010,800	1,373,777,710	3,233,090

2.5. Гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байгаагаас хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгө ашиглагч байгууллагын өмчлөх эрхэд шилжээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 22,4 хувь буюу 312,0 сая төгрөгөөр төсөвт байгууллагуудад 6 автомашин худалдан авч, хөрөнгийг ашиглагч байгууллагын санхүүгийн тайланд тусгасан боловч 4 суудлын автомашин тухайн ашиглагч байгууллагын нэр дээр байхгүй байна. Тухайлбал:

- Аудитаар Шинэжинст сумын ЗДТГ-т худалдан авсан Land Cruiser 200 маркын суудлын автомашин нь Улаанбаатар хотын харьяат иргэн Ц.Батдоржийн нэр дээр, Богд сумын ЗДТГ-т худалдан авсан Land Cruiser 100 маркын суудлын автомашин нь Баянхонгор аймгийн харьяат “Баянхонгор төмөрт” ХХК-ийн нэр дээр, Эрдэнэцогт сумын ЗДТГ-т худалдан авсан Land Cruiser 200 маркын суудлын автомашин нь Улаанбаатар хотын харьяат иргэн Э.Баярмагнайн нэр дээр, аймгийн ЗДТГ-т худалдан авсан Toyota Land Cruiser 200 маркын суудлын автомашин нь Баянхонгор Эрчим хүч ЦТХХК-ийн нэр дээр эзэмшилтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2⁶ дахь заалтыг зөрчсөн тул суудлын автомашинуудыг ашиглагч байгууллагын нэр дээр шилжүүлж, зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.
- Эрүүл мэндийн төвүүдийн багийн эмч нарын ажлын хэрэгцээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 10 суманд 18 мотоцикл олгосон бөгөөд үүнээс Баянговь сумын багт хуваарилсан 4 мотоциклоос бусад 29,1 сая төгрөгийн 14 мотоциклийн гэрчилгээг байгууллагын нэр дээр гаргуулаагүй зөрчилд аймгийн ЭМГ-т албан шаардлага хүргүүлэв.

БҮЛЭГ 3

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх?

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн зарим хөрөнгө оруулалтын үр нөлөө гараагүй байна.

3.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

⁶ " Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна"

2017 онд орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн дараахь төсөл, арга хэмжээ нь үр дүн муутай, зарим тоног төхөөрөмжийг одоогоор ашиглаагүй байна. Тухайлбал:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас Богд, Шинэжинст, Эрдэнэцогт зэрэг сумдад суудлын автомашин худалдан авах зардалд тус бүр 35,0 сая, нийт 105,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байхад орон нутгийн төсвөөс нэмж 45,0 сая төгрөг баталж, шатахуун зарцуулалт өндөртэй хөрөнгө бэлтгэж төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

2. Баянхонгор аймгаас Зээлийн батлан даалтын санд хөрөнгө төвлөрүүлэн зээлийн батлан даалтын үйл ажиллагаагаар дамжуулан аймгийн нутаг дэвсгэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн эх үүсвэр олж авах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг дарга Зээлийн батлан даалтын сантай 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр 07 тоот хамтран ажиллах гэрээ байгуулж, аймгийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/565 тоот захирамжаар 50,0 сая төгрөгийг тус санд шилжүүлсэн байна. Тус зардлыг аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд авлагаар тусгасан бөгөөд гэрээний 3.5-т заасан “Зээлийн батлан даалтын дэлгэрэнгүй мэдээ тайланг аймгийн ЗДТГ-т улирал тутам хүргүүлнэ”, 6.1-т заасан “Талууд гэрээний биелэлтийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан дүгнэнэ” гэж заасныг дүгнээгүй, биелэлтийг тооцож ажиллаагүй тул гэрээний дээрх заалтуудын хэрэгжилтийг тооцож, хариу ирүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

3. Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газарт орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн 7,7 сая төгрөгийн олон үйлдэлт хөрөө рам, уран хөрөө, токарийн машин зэрэг мужааны тоног төхөрөмжийг хоригдлын хөдөлмөр эрхлүүлэх ажлын байрны засвар дуусаагүйн улмаас ашиглаж эхлээгүй нь цаг үеэ олоогүй, шаардлагатай хугацаанд хөрөнгийг олгоогүйтэй холбоотой байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-аар дамжуулан 560,0 сая төгрөгийг 14 иргэн, аж ахуйн нэгжид олгожээ.

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК аудитын явцад зээлдэгчийн бэлэн байдлыг хангаж, аудитад хамруулах байтал 3 зээлдэгч эзгүй байсан тул аудитад хамрагдаагүй, аудитаар 11 зээлдэгчийн үйл ажиллагаатай танилцав.

Эдгээр зээлдэгчдээс хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй зээлдэгчийн үйл ажиллагааг үзэхдээ аймгийн МХГ-ын эрүүл ахуйн байцаагч нартай хамтран

шалгахгаар төлөвлөсөн боловч аймгийн МХГ-аас Зөрчлийн тухай хуулийн дагуу шалгах процесс нарийн, цаг хугацаа их шаардагдана гэсэн тайлбар өгсөн тул аудитад мэргэжлийн байгууллагыг татан оролцуулаагүй болно.

Зээлд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайланг мэдээлсэн байдлыг

тодруулахад зарим аж ахуйн нэгж санхүүгийн тайланг тушаагаагүй, хугацаа хоцроосон, зээлээр үндсэн хөрөнгө авсныг нотлох боломжгүй байна.

Хөнгөлөлттэй зээлд хамрагдснаар 32 ажлын байр шинээр болсон гэх боловч нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаар холбогдох байгууллагаас лавлагаа авахад “Нэм хонгор” ХХК-аас бусад аж ахуйн нэгж нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй байна. Иймд зээл хэрэгжсэний үр дүнд бодитоор бий болсон ажлын байрыг мэргэжлийн байгууллагын баримт материалд тулгуурлан тайлан мэдээг гаргаж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитад хамрагдсан зээлдэгчдээс дараахь зээлүүдийн хэрэгжилт хангалтгүй, зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, ажлын байр нэмэгдүүлээгүй, зээлийн гэрээнд заасан хугацаанд төлөөгүй зэргээр хөнгөлөлттэй зээлийн үр дүнг гараагүй байна. Тухайлбал:

- “Баялаг номгон” ХХК-ийн сав баглаа боодол үйлдвэрлэх зориулалтаар авсан 70,0 сая төгрөгөөс хэвлэлийн машин, лазер зүсэгч машин, горив гаргагч төхөөрөмж зэргийг 60,5 сая төгрөгөөр авсан гэх боловч түүнийг баримтаар нотлоогүй, 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагааг тасралтгүй явуулахаар гэрээнд заасан байхад Ажилсаг төвийн 1 өрөө байранд эдгээр тоног төхөөрөмжийг байршуулсан боловч үйл ажиллагааг эхлээгүй зөрчилтэй тул 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор үйл ажиллагааг эхлүүлэх албан шаардлагыг өгөө.

- “Номгон хүнс” ХХК үйл ажиллагааг өргөжүүлж, хэвтэй гоймон үйлдвэрлэхээр 50,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан боловч зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй тул төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

- Монгол тоглоом үйлдвэрлэхээр хөнгөлөлттэй зээл авсан “Нэм хонгор” ХХК 1,0 сая төгрөгийн зээлийг хугацаанд нь төлөөгүй хугацаа хэтрүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

- Эрчимжсэн аж ахуй, сувилал эрхлэхээр 45,0 сая төгрөгийн зээл авсан “Гурван цахир” хоршоо үйл ажиллагаа эрхлэхээр адуу худалдан авч Заг суманд оторлуулж байгаа гэсэн боловч аудитаар нотлох боломжгүй, зээлийн эргэн төлөлтийг хугацаанд нь

хийгээгүй зэрэг зөрчилтэй тул хугацаа хэтэрсэн зээлийн 6,0 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

- “Баянхонгор төмөрт” ХХК төмөр хашаа, хайс үйлдвэрлэхээр 62,0 сая төгрөгийн зээл авч, 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс үйл ажиллагааг эхлүүлэхээр гэрээнд заасан байхад үйл ажиллагаа жигдрээгүй, төсөлд заасан тоног төхөөрөмжийг бүрэн аваагүй тул зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

- Баянлиг суманд цагаан будаа тариалахаар 95,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан “GIMEX” ХХК-ийн ажлын гүйцэтгэлийг газар дээр нь очиж үзэхэд 2017 онд 5 төрлийн үр туршиж үзэн үрсэлгээ хийсэн байна. Хийсэн үрсэлгээг Дархан-Уул аймгийн Эрдэм шинжилгээний лабораторит шинжлүүлж Хятадын хар Мөрөний цагаан будааны үр ургах боломжтой гэж хэлсэн боловч төслийн хэрэгжилтийг үе шатаар төлөвлөөгүйгээс эхний жилийн хэрэгжилтийг тооцох боломжгүй учир үйл ажиллагааг жигдрүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

“Баянхонгор хөгжлийн корпораци” ХХК-аар дамжуулан хөнгөлөлттэй зээл авсан 3 аж ахуйн нэгжид 227,0 сая төгрөгийн албан шаардлага өгч, 3 аж ахуйн нэгжид 57,0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

Орон нутгийн төсвөөс “Баянхонгор хөгжлийн корпораци” ХХК-аас зээлдэгч нарын үйл ажиллагаанд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах мэдэгдлийг тухай бүрт нь хүргүүлж ажилласан боловч зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй, зээлийг хугацаа хэтрүүлсэн зээлдэгч нарыг зээлийн гэрээнд заасны дагуу гэрээг цуцлах арга хэмжээг авч ажиллаагүй байна. Иймд хөнгөлөлттэй зээл авсан аж ахуйн нэгж, иргэдийн зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулж, зөрчил гарсан тухай бүрт хууль хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлж байх зөвлөмжийг аймгийн “Баянхонгор хөгжлийн корпораци” ХХК-д хүргүүлэв.

“Баянхонгор хөгжлийн корпораци” ХХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 19 тоот тогтоолоор баталсан журмын 2-т заасан Зээлийн хүүг залруулах, зээлдэгч нартай байгуулсан хөрөнгө оруулалтын зээлийн гэрээ нь хууль, журамд нийцэж байгаа эсэхийг холбогдох байгууллагаар шалгуулж зөвлөгөө авах” зөвлөмж хүргүүлж ажилласан болно.

3.2 Тендерийн хэмнэлтийг бусад зардалд зарцуулаагүй байна.

2017 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан 641,2 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээний ажилд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 637,9 сая төгрөгийн гэрээ байгуулан, тендер сонгон шалгаруулалтын хэмнэлтээс 3,3 сая төгрөг хэмнэж, хэмнэлтийг зарцуулаагүй, аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн А/873 тоот захирамжаар хасч 3 удаа отгон Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.3⁷ дахь заалтыг баримталж ажилласан байна.

3.3. Зарим хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын заасныг зөрчиж 2017 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон дараахь хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Тухайлбал:

Аймгийн Прокурорын газрын дээврийн засварын ажилд 31500,0 мянган төгрөг батлагдаж, харьцуулалтын аргаар тендер сонгон шалгаруулалт явуулж, шаардлага хангасан үнийн санал ирээгүй тул гэрээ шууд байгуулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлсний дагуу аймгийн Засаг дарга Зэвсэгт хүчний 339 дүгээр ангитай 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдөр 31021,2 мянган төгрөгийн гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгэсэн байхад байгуулагын санхүүгийн тайланд их засварын ажлыг 31500,0 мянган төгрөгөөр бүртгэсэн тул 478,8 мянган төгрөгөөр хөрөнгийн дүнг залруулах албан шаардлагыг хүргүүлэв.

Сумдын Эрүүл мэндийн төвийн багийн эмч нарыг унаажуулахаар санхүүжүүлсэн 20 ширхэг мотоциклоос 1690,0 мянган төгрөгийн үнэ бүхий 1 ширхэг мотоциклийг Бөмбөгөр сумын байгаль хамгаалах иргэдийн бүлэгт олгосон байна. Иймд тус хөрөнгийг Бөмбөгөр сумын ЗДТГ-ын бүртгэлд орлого авах албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитаар нийт 540,3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 57,0 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 483,3 сая төгрөгийн 7 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 9 зөрчилд холбогдох эрх бүхий албан тушаалтнуудад зөвлөмж хүргүүлэв.

⁷ " хөрөнгө оруулалтын худалдан авах үйл ажиллагааны үед нэгжид ногдох өртөг, үнэ, тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл"

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг тооцоогүй, энэ талаар нэгдсэн судалгаа байхгүй, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй улсын төсвөөс санхүүждэг байгууллагуудад хөрөнгө оруулалт хийж, Төсвийн тухай хуулийн 6.6.6 дахь заалтыг зөрчсөн байна.
2. Хөрөнгө худалдан авсны дараа худалдан авах ажиллагааг зохион байгуулсан, шууд гэрээ байгуулахдаа техникийн тодорхойлолтод заасан нөхцлийг харгалзаж үзээгүй зэргээр холбогдох хуулийг зөрчсөн байна.
3. Гүйцэтгэгчтэй байгуулж буй гэрээнд гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд тооцох хариуцлагыг тодорхой тусгаагүй, гэрээний үүргээ зөрчиж, ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй байхад гүйцэтгэгчид хариуцлага тооцож ажиллаагүй байна.
4. Зарим хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн гэрчилгээг аваагүй, ашиглагч байгууллагын өмчлөх эрхэд шилжээгүй байна.
5. 2017 онд орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гэрээний гүйцэтгэлд захиалагчийн хяналт тавьж ажиллаагүйгээс хөрөнгө оруулалтын үр дүн гараагүй.
6. Ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор олгосон хөнгөлөлттэй зээл авсан зарим аж ахуйн нэгж, иргэд зээлийн гэрээнд заасан үйл ажиллагааг эхлүүлээгүй, зээлийг хуваарийн дагуу төлөөгүй, ажлыг байрыг нэмэгдүүлээгүй зэргээр хөнгөлөлттэй зээлийн үр нөлөөг гаргаж ажиллаагүй байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Ц.Отгонбаяр танаа:

1. Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын дагуу өргөн барьсан төслийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээгээр батлах.

Аймгийн Засаг дарга Г.Батжаргал танаа:

2. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар батлуулахдаа Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын дагуу бэлтгэж байх.

3. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг хэрэгжүүлж, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй төсөл арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх.

4. Тендерийн үнэлгээний хорооноос хүргүүлсэн зөвлөмжийн дагуу шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэхдээ ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг мөрдөж ажиллах.

5. Гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулахдаа гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд тооцох хариуцлагыг тодорхой зааж, үүргээ биелүүлээгүй нөхцөлд хариуцлага тооцож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Гачин ламын сүмийг сэргээн засварлах ажлыг гэрээний дагуу бүрэн хийж дуусаагүй байхад ашиглалтад хүлээн авсан улсын комисст ажилласан холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох.

7. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн санхүүгийн тайланд тусгасан эсэх, тухайн хөрөнгийн эзэмших эрх нь ашиглагч байгууллагад шилжсэн эсэхэд хяналт тавьж ажиллах.

“Баянхонгор хөгжлийн корпораци” ХХК-ийн

гүйцэтгэх захирал С.Батцэрэн танаа:

8. Хөнгөлөлттэй зээл авсан зээлдэгчдийн зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулж, зөрчил гарсан тухай бүрт хууль хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлж байх.

9. Төслийн үр дүнд бодитоор бий болсон ажлын байрыг мэргэжлийн байгууллагын баримт материалд тулгуурлан тайлан мэдээг гаргаж байх.

Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2018 оны 09 дүгээр сарын 15-ны дотор аймгийн Төрийн аудитын газарт хариу ирүүлэх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ